

“ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-НД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Огноо: 2023.06.01

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ДУА-2023/40-1-ШТА-ГА	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	АЗДТ-ын ХБТХОХ, БОАЖГ, МГХТГААТҮГ, Татварын хэлтэс, Сумдын Засаг дарга
Аудитын нэр:	“Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн”		
Аудит хийсэн бүтэц, нэгж:	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Аудитын 2-р нэгж

Хоёр. Аудитын үр дүн:

2.1 Аудитын зорилго, хамрах хүрээ:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

“Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Хог хаягдлын менежментийг сайжруулах талаар баримталж буй бодлогыг хууль эрх зүйн хүрээнд оновчтой төлөвлөсөн эсэх;
- Хог хаягдлын менежментийг сайжруулах талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй эсэх.

Аудитын үндэслэл, хамрах хүрээ:

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ч.Бэрхсайхан, аудитор Г.Самданцоодол, Л.Уранбилэг нар тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2023 оны 08 сарын 16-ны өдрөөс 11 сарын 24-ны хооронд хийж гүйцэтгэлээ. Улсын хэмжээнд “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр” 2014 онд батлагдаж 1 дүгээр үе шат 2014-2017 он, 2 дугаар үе шат 2018-2022 онд хэрэгжсэн байна.

Хог хаягдлын тухай хуулийн 8.1.2-д зааснаар Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2018 онд “Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр”, түүнийг 2018-2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2 үе шаттай байхаар баталсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтэд 2024 онд төгсгөлийн үнэлгээг хийхээр байна.

Аудитын дүн:

БҮЛЭГ 1. Аймгийн бодлого төлөвлөлтөд хог хаягдлын менежментийг сайжруулахтай холбоотой хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг бүрэн төлөвлөөгүй, хэрэгжилтийг бодитой үнэлж дүгнээгүй байна

1.1 Хог хаягдлын менежментийг сайжруулахтай холбоотой аймгийн бодлого, төлөвлөлт хангалтгүй, хоорондын уялдаа холбоо муу байна.

1.1.1 Хог хаягдлын тухай хууль болон хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрт туссан зарим чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хог хаягдлын тухай хуулийг 2017 онд шинэчлэн найруулж баталснаар хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах зэрэг харилцааг зохицуулж байна. Хуулийн хүрээнд Монгол Улсын хэмжээнд “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг хоёр үе шаттай хэрэгжүүлэхээр батлан хэрэгжүүлсэн байна. Хөтөлбөрийн эхний үе шатыг хог хаягдлыг бууруулах эрх зүй, зохион байгуулалтын орчныг боловсронгуй болгож, менежментийг сайжруулах, дэд бүтцийн болон санхүүгийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр 2014-2017 онд хэрэгжүүлэхээр баталсан бол хоёр дахь үе шатыг хог хаягдлаас үүдэлтэй орчны доройтлыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, ногоон хэрэглээний соёл, нийгмийн хариуцлагын ойлголтыг төлөвшүүлж, хог хаягдлын зохистой менежментийн тогтолцоо бий болж цэвэр эрүүл орчин бүрдүүлэх чиглэлээр 2018-2022 онд хэрэгжүүлэхээр төвлөрөн баталжээ.

Хог хаягдлын тухай хуульд зааснаар аймгийн ИТХ дараах хөтөлбөр, журам, тарифыг батлах ёстой. Үүнд:

- ❖ Хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөр;
- ❖ Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам;
- ❖ Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тариф.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 12 дугаар тогтоолоор “Дундговь аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр”, “Хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөө”-г 2018-2023 онд хэрэгжүүлэхээр тус тус баталсан байна. Хуульд заасан хөтөлбөр, төлөвлөгөөг баталсан боловч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагууд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлээгүй, хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнаагүй, үнэлгээ хийгээгүй байна.

Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөрийн хувьд хэрэгжилтийг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор сумын ИТХ-д тайлагнаж, биелэлтийг дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг даргад ирүүлж байх, 2018-2020 оны нэгдүгээр үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн дуусгаж 2021 онд хөтөлбөрийн хэрэгжилтэд анхан шатны үнэлгээг хийхээр заасан боловч хэрэгжилтийг тайлагнаагүй, үнэлгээ хийгээгүй байна.


Энэ нь ИТХ-аас тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьдаггүй, аймгийн ЗДТГ-аас хэрэгжүүлэгч байгууллагуудад үүрэг чиглэл хүргүүлэх, нэгтгэн удирдах ажил хангалтгүй, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо муу байгаатай холбоотой байна.

БҮЛЭГ 2. Хог хаягдлын менежментийг сайжруулах талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүн муутай байна

Ажиллах хүчин, машин механизмын хүрэлцээгүй байдлаас шалтгаалан айл өрхийн хог хаягдлыг тогтмол хугацаанд ачихгүй байна

Дундговь аймаг 2022 оны статистик мэдээгээр 14.9 мянган өрхийн 46.3 мянган хүн амтай үүнээс 22.0 мянган хүн ам нь төв суурин газар амьдарч байгаагийн 4.1 мянган өрхийн 13.0 мянган хүн ам нь Сайнцагаан сумын төвд амьдарч байна. Сүүлийн 3 жилийн мэдээгээр төв суурин газрын айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас жилд 79.2-86.4 мянган тонн энгийн хог хаягдал гарч байна. *Хавсралт № 2 -оос харна уу.*

Айл өрхийн энгийн хог хаягдлыг төвлөрсөн цэг рүү ачиж тээвэрлэх үйл ажиллагааг Сайнцагаан суманд Мандалын гэгээ хот тохижуулах газар ААТҮГ эрхэлж байгаа бол бусад сумд хувь хүнтэй гэрээ байгуулан хог хаягдлыг ачиж тээвэрлэх ажлыг зохион байгуулж байна. Сайнцагаан сумын хэмжээнд гэр хорооллын 2,749 өрх, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон 1,243 өрхийн хог хаягдлыг зориулалтын 8 автомашинаар ажлын өдрүүдэд ажлын 8 цагаар ачиж тээвэрлэж хогийн төвлөрсөн цэгт асгадаг байна.



- Сайнцагаан сумын гэр хорооллын 5 багт 6 автомашин ажилладаг бөгөөд нэг айл өрхийн хог хаягдлыг ачиж зайлуулах хоногийн эргэц Мандалын гэгээ хот тохижуулах ОНӨААТҮГ-ын мэдээгээр урин дулааны улирлын үед 27-40 хоног, галлагаатай байх өвөл, хаврын улирлын хугацаанд хог хаягдлын хэмжээ өсөж нэг өрхийн хогийг ачих хоногийн эргэц 30-43 хоног байдаг гэж мэдээлсэн. Гэвч аудитын явцад хог хаягдал ачиж

тээвэрлэх явц, хогоо ачуулсан болон хогоо ачуулахаар хүлээж байгаа айл өрхүүдээс авсан судалгаагаар Айраг багт 60-аас дээш хоног, Мандал багт 45-60 хоног, Боржигон баг, Аривжих багийн замын зүүн хэсэгт 30-40 хоног, Аривжих багийн Шанд, Зоог хороололд 90-120 хоногийн өмнө хамгийн сүүлд хог хаягдал ачсан гэж хариулсан. Аудитын явцад Хот тохижуулах газраас гаргуулан авсан 2022 оны хог хаягдлын ачилт тээвэрлэлтийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж үзэхэд Сайнцагаан сумын хэмжээнд гэр хорооллын 2,749 айл өрхийн хог хаягдлыг давхардсан тоогоор 9,883 удаа ачиж тээвэрлэсэн буюу жилд дунджаар нэг айл өрхийн хог хаягдлыг 3-4 удаа ачиж тээвэрлэдэг буюу эргэц 100.1 хоног байна. суурилсан санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгож байна.

- Аудитаар аймгийн төвийн ачиж тээвэрлэсэн хог хаягдал, хог ачигч, хог тээврийн жолооч, автомашины тоон мэдээллийг бусад аймгуудтай харьцуулж үзлээ. Мандалговь хотын хог хаягдлын тээвэрлэлтэд явж байгаа нэг автомашин буюу жолооч жилд 9,602 тонн хог хаягдлыг тээвэрлэж байгаа бол Даланзадгад хот 2,933 буюу 3.3 дахин, Чойр хот 3,873 буюу 2.5 дахин, Сайншанд хот 3,974 буюу 2.4 дахин бага хог тээвэрлэж байна. Мандалговь хотод нэг хог ачигч жилд 5,401 тонн хог хаягдал ачиж байгаа бол Даланзадгад хот 1,634 буюу 3.3 дахин, Чойр хот 2,767 буюу 2.0 дахин бага байна.

2.1.2 Энгийн хог хаягдлыг зайлуулах, булцлах үйл ажиллагааг зөвшөөрөлгүй этгээдээр гүйцэтгүүлж байгаа бөгөөд түүнд тавих хяналт хангалтгүй байна.

- БОАЖГ-ын мэдээгээр сумын төвүүдэд энгийн хог хаягдал аймгийн нэгдсэн дүнгээр 2020-2022 онуудад 79.2-86.4 мянган тонн гарсан. Үүнээс нийт энгийн хог хаягдлын 86.3-91.4 хувь болох 65.6-79.0 мянган тонн нь Сайнцагаан суманд ногдож байна. Нийт энгийн хог хаягдлыг тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт асгаж дарж булшилсан байна. Дээрх тоон мэдээлэл нь зөвхөн сумын төвийн айл өрх, албан байгууллагаас гарч байгаа хог хаягдал бөгөөд хөдөөгийн малчин өрхүүдийн хог хаягдал ороогүй, нэгтгэсэн тоон мэдээлэл байхгүй байна.
- сумдын төвлөрсөн хогийн цэгүүдэд мэргэжлийн байгууллагаас стандартын шаардлага хангасан эсэх талаар хяналт шалгалт хийж дүгнэлт гаргадаггүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдэхгүй байна. Энэ нь БОАЖС-ын 2018 оны А/445 тушаалаар батлагдсан “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар”-ын 3.2-г зөрчиж байгаа бөгөөд байгаль орчны бохирдол үүсэх, улмаар хүн амын эрүүл мэндэд хохирол учрах эрсдэлтэй байна.
- Зарим төвлөрсөн хогийн цэгүүдэд хог хаягдлыг түрэгч механизмаар түрж бөөгнүүлэн, нүх ухаж дарж булшлах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа боловч энэ нь хог хаягдлыг газрын хөрсөн дээр шууд хаяж байгаа тул хог хаягдал хөрсөнд шингэж хөрс, ургамал, гүний ус зэрэгт бохирдол үүсэх эрсдэлтэй байна.

2.1.3 Бүх сумд төвлөрсөн хогийн цэгтэй байгаа боловч ихэнх сумд хашаажуулалт, харуул хамгаалалт байхгүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгээгүй, хяналт шалгалт хангалтгүй байна

- Дундговь аймгийн 15 суманд төвлөрсөн хогийн цэг тус бүр 1 байгаа бөгөөд талбайн нийт хэмжээ 138.3 га байгаагаас 28.7 га талбай нь хашаатай, 109.6 га талбай хашаагүй байна. Хашаажуулаагүй нийт талбайн 61.4 га талбайд хур хогтой, түүний 35 га талбай нь зөвхөн Сайнцагаан суманд байгаа бөгөөд хог хаягдлын хэмжээ тогтмол нэмэгддэг байна. БОАЖГ-ын ирүүлсэн судалгаагаар Говь-Угтаал, Луус, Дэлгэрхангай, Сайнцагаан, Эрдэнэдалай сумд төвлөрсөн хогийн цэгээ хашаажуулсан, Эрдэнэдалай, Говь-Угтаал, Өндөршил, Дэрэн сумд төвлөрсөн хогийн цэгийн тодорхой хэсгийг камержуулсан, Эрдэнэдалай сум хогийн цэг сахиул харуултай, ажлын байрыг шийдвэрлэсэн байна. Төвлөрсөн хогийн цэгүүдийг хашаажуулаагүй 10 сум, камержуулаагүй 11 сум, сахиул харуулгүй 14 сум, хогийн цэгийг шуух, түрэхэд ашиглах зориулалттай түрэгч механизм (ковш) 9 суманд 10 ширхэг байгаагийн 8 нь хэвийн 2 нь эвдэрсэн ашиглагдахгүй байгаа (Сайнцагаан, Эрдэнэдалай) бол, 6 сум (Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Луус, Хулд) ковшгүй байна.

- Харуул хамгаалалт, камерын хяналтгүйгээс нийт сумдад иргэд, аж ахуй нэгжүүд төвлөрсөн хогийн цэгийн талбайгаас гадуур хяналтгүй хог хаягдлаа асгаснаас талбайн хэмжээг тэлэх, хашаажуулаагүйгээс хог хаягдал салхи, үер усны нөлөөгөөр байгальд тархах, эрүүл орчныг бохирдуулах, мал амьтан хогийн цэгт орж эрсдэлд орох, түрэгч механизмгүйгээс хог хаягдлыг шуух, дарж булшлах, устгах ажил хийгдэхгүй, бэлтгэсэн нүх хурдан дүүрэх, улмаар хуримтлагдсан хогийг түрж, дарж булшлах, шинээр хогийн цэг байгуулахад хөрөнгө санхүү, цаг хугацаа ихээр шаарддаг зэрэг сөрөг үр дагаврууд бий болж байна.

2.1.4 Аюултай хог хаягдлын стандарт, хууль журмын дагуу бүрэн устгахгүй байна

- Аймгийн БОАЖГ-ын мэдээнд аймгийн нэгдсэн дүнгээр сумын төвүүдэд аюултай хог хаягдал 2020-2022 онуудад 90.6-145.5 тн гарсан. Үүний 82.4-96.3 хувь болох 74.7-136.7 тонн нь Сайнцагаан, Гурвансайхан, Дэлгэрхангай, Баянжаргалан, Говь-Угтаал сумдын уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж болон аймгийн төвийн авто засварын газруудаас гардаг ашигласан бодис, түүний сав баглаа боодол, ашигласан техникийн тос, тосол, материал байгаа бол үлдсэн 3.7-17.6 хувийг сумдын Эрүүл мэндийн төвүүдээс гарч буй эмнэлгийн аюултай хог хаягдал эзэлдэг байна.

2.2 Хог хаягдлын хураамжийн орлогын төвлөрүүлэлт хангалтгүй, орлогыг хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлахад зарцуулахгүй байна

- 2.2.1 Сүмд хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоосон боловч хэрэгжилт хангалтгүй байна.



Хог хаягдлын тухай хуулийн 8.7.2-д заасан аргачлалаар сумд 1 айл өрхийн хог хаягдлыг ачиж тээвэрлэхэд гарч буй зардлыг огт тооцдоггүй байна. Тус аргачлалаар Сайнцагаан сум буюу аймгийн төвийн гэр хорооллын 1 айл өрхийн хог хаягдлыг 1 удаа ачиж тээвэрлэхэд гарах зардлыг тооцож үзэхэд 13,836 төгрөг, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон 1 өрхийн хог хаягдлыг 1 удаа ачиж тээвэрлэхэд гарах зардал 911.6 төгрөг болж байна. Судалгаанд үндэслэн тооцоолол хийхэд ХТГ-аас гэр хороололд одоо байгаа 10 автомашинаар ажлын өдрүүдэд ажлын 8 цагаар тогтмол гарч 1 автомашин өдөрт дунджаар 15 айл өрхийн хог хаягдлыг ачиж тээвэрлэнэ гэвэл хог ачилтын хоногийн эргэц 18.3 хоног болж сард 1 айл өрхийн хог хаягдлыг зайлуулах зардал 22,968.0 төгрөг, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон өрхийн хувьд одоогийн нормоор ажиллахад хог ачилтын хоногийн эргэц 2.5 буюу сард ногдох зардал 10,939.4 төгрөг байна. Сайнцагаан сум нь сард гэр хорооллын нэг айл өрхөөс 3,000 төгрөгийн хог хаягдлын үйлчилгээний хураамж авч байхад, нэг айл өрхийн хог хаягдлыг зайлуулах зардал 22,968 төгрөг байгаа нь 19,968 төгрөгөөр буюу 7.7 дахин их байна.


2.2.2 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг зарим сүмд хуульд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй бол 2 сүм огт зарцуулалт хийгээгүй байна.

Аймгийн хэмжээнд 2022 онд хог хаягдлын үйлчилгээний хураамжаас 171.4 сая төгрөг төсөвт төвлөрүүлсэн ч 57.7 сая төгрөг буюу 33.6 хувийг хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлаар сумдын ЗДТГ-аас зарцуулсан байна. Хураамжийн орлогын гүйцэтгэлтэй харьцуулахад 12 сум хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогоос төвлөрүүлсэн орлогыг зориулалтын дагуу бүрэн зарцуулаагүй бол Өндөршил, Дэлгэрхангай сумд огт зарцуулалт хийгээгүй байна.

2.2.3 Хог хаягдлыг ангилах орчин бүрдээгүй, дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах арга хэмжээ хангалтгүй байна

Аймгийн бодлогын баримт бичигт хог хаягдлыг ангилан ялгахтай холбоотой хог ангилан ялгах савны тоог нэмэгдүүлнэ гэсэн нэг арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бол хог хаягдлыг ангилан ялгах, дахивар хог хаягдлыг цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, тушаах, хог ангилан ялгах дадал, хэвшил суулгах олон нийтэд чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах талаар арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна. Хог хаягдлыг дахин ашиглаж, боловсруулан эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоотой тооцоо судалгааг аймгийн бодлого хариуцсан хэлтэс, мэргэжлийн байгууллагаас гаргадаггүй байна.

Аймгийн дүнгээр 2021 онд 3 сум 13 тонн, 2022 онд 3 сум 47.5 тонн, 2023 оны 8 сарын дүнгээр 4 сум 82.6 тонн хогийг ангилан ялгаж Улаанбаатар хот руу тээвэрлэн хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн бол Адаацаг, Дэрэн, Эрдэнэдалай сумд дахивар хог хаягдлыг авч нийлүүлэх ажил эхлэлийн шатанд байна. Хог ангилан ялгах савтай болсон ч хог ангилан ялгах, дахивар нөөцийг цуглуулах ажлыг эхлүүлээгүй 8 сум байгаа бөгөөд тус сумдад 53ш хог ангилан ялгах сав байршсан байна. Сүүлийн 3 жилийн дүнгээр 143.1 тонн дахин боловсруулах боломжтой хог хаягдал цуглуулж, үйлдвэрт тушаасан нь 3 жилийн нийт энгийн хог хаягдлын 0.058 хувь байна.



ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Хог хаягдлын менежментийг сайжруулахтай холбоотой зорилт, арга хэмжээг үндэсний болон салбарын бодлого хөтөлбөртэй уялдуулан боловсруулаагүй, хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, хог хаягдлын менежментийг сайжруулах бодлого төлөвлөлт хангалтгүй байна.
2. Бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхдөө суурь тооцоо судалгаа хийгээгүй, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, санхүүжилтийн эх үүсвэр тодорхой бус, дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ нь хоорондоо уялдаагүй, хэрэгжилтийг тайлагнаж байгаа боловч бодит үр дүнг тооцон үнэлээгүй байна.
3. Айл өрхийн хог хаягдлыг ачих, тээвэрлэх, булшлахтай холбоотой тоон мэдээллийг нэгтгэн бүртгэж, дүн шинжилгээ хийн, айл өрхийн хог ачилтын эргэц хоног, хүлээгдлийн хугацааг тооцож ажиллахгүй байна.
4. Хот тохижуулах газрын цалин хөлс хангалтгүйгээс хог тээврийн жолооч, ачигч нар тогтвор суурьшилтай ажилладаггүй, хүний нөөц дутагдалтай, хог тээврийн автомашины хүрэлцээ муу зэргээс айл өрхийн хог хаягдлыг ачих хугацаа удаашралтай байна.
5. Аюултай хог хаягдлыг хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөлтэй ААНБ цөөн байдаг, иргэд аюултай хог хаягдлын талаар ойлголт, мэдээлэл дутмаг, аюултай хог хаягдлыг цуглуулах, устгах үйл ажиллагаа хангалтгүй байна.
6. Сумдын төвлөрсөн хогийн цэг нь байнгын харуул хамгаалалт, хяналт байхгүй, иргэдийн хариуцлагагүй үйлдлийн улмаас зориулалтын бус газар хог хаягдал их төвлөрсөн. Хог хаягдлыг дарж булшлах ажил тогтмол хийдэггүй, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байгаа боловч байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийж, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч ажиллахгүй байна.
7. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тариф бодитой биш, зарим сумд нь батлуулаагүй, батлагдсан тарифт үндэслэн үйлчилгээ үзүүлэгч хувь хүн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажиллаагүй байна.
8. Хог хаягдлын хураамжийн ногдуулалт хийх албан хаагч тодорхойгүй, татварын нэгдсэн системд хураамж төлөх айл өрх, албан байгууллагын мэдээллийг оруулдаггүй, хураамжийг цахилгааны төлбөртэй хамт авч байх ажлыг сумд хэрэгжүүлж эхлээгүй зэргээс шалтгаалан орлого төвлөрүүлэлт хангалтгүй байна.
9. Барилгын болон халаалтын зуухнаас гарсан хог хаягдалд батлагдсан хураамжийн дагуу төлбөрийн ногдуулалт хийснээр 78,709,266.00 /Далан найман сая долоон зуун есөн мянга хоёр зуун жаран зургаа/ төгрөг төсөвт төвлөрөх боломжтой байна.
10. Иргэд хогоо ангилан ялгах дадал хэвшил суугаагүй, айл өрхийн ойр орчимд ангилан ялгах хогийн сав байдаггүй, дахивар нөөц хүлээн авах цэг, дахин боловсруулах үйлдвэр, цех байхгүй зэргээс шалтгаалан хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагаа үр дүн муутай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Хог хаягдлын менежментийг сайжруулахтай холбоотой зорилт, арга хэмжээг үндэсний болон салбарын бодлого, хөтөлбөрт үндэслэн аймгийн бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж, хэрэгжилт үр дүнг тооцон ажиллах, хуульд заасан эрх үүргийн хүрээнд хөтөлбөр, журам, тарифыг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллаж байх;
2. Хог хаягдлын менежментийг сайжруулахтай холбоотой зорилтуудыг оновчтой дэвшүүлж, түүнд хүрэхэд шаардлагатай арга хэмжээг бүрэн тодорхойлж, жил бүр хийгдэх ажил, төсвийн задаргааг нарийвчлан тооцож, санхүүжилтийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлт, жил бүрийн хүрэх түвшинг бодитой төлөвлөн, хэрэгжилт үр дүнг тооцон ажиллах;
3. Сумдын төвлөрсөн хогийн цэг нь стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд шалгалт хийн дүгнэлт гаргаж, зөрчлийг арилгах зөвлөмж, шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг хангуулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
4. Хогоо ангилан ялгах дадал хэвшил суулгах сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж, айл өрхийн ойр орчимд ангилан ялгах хогийн савны тоог нэмэгдүүлэх, дахивар нөөц хүлээн авах цэг, дахин боловсруулах үйлдвэр, цех байгуулах боломжийг бүрдүүлэн, хэрэгжүүлэгч байгууллага, хувь хүнд дэмжлэг үзүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах хог хаягдлын тоог нэмэгдүүлэн ажиллах;
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан аюултай хог хаягдлын агуулахын дутуу байгаа ажлыг гүйцэтгэгч аж ахуй нэгжээр хийлгэх, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, менежмент хариуцагчийг сонгон шалгаруулж, үйл ажиллагааг эхлүүлэх;

Мандалын гэгээ хот тохижуулах газрын Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. Дундговь аймгийн Мандалын гэгээ хот тохижуулах газар ААТҮГ-ын албан хаагчдын одоо авч байгаа цалин хөлс, нэмэгдэл, урамшуулалд дүн шинжилгээ хийж, шинэчлэн тогтоох ажлыг хэрэгжүүлэх;

Байгаль орчин, аялал жуулчлалын газарт:

1. Иргэд, олон нийтийн дунд аюултай хог хаягдал гэж юу болох, түүний хор хөнөөл, аюултай хог хаягдлыг хэрхэн цуглуулж хадгалах, хаана тушаах талаар анхан шатны ойлголт мэдлэгийг олгох, дадал хэвшил суулгах, сургалт нөлөөллийн арга хэмжээ, аяныг тогтмол зохион байгуулах;

Дундговь аймгийн Мандалын гэгээ хот тохижуулах газар ААТҮГ-т:

1. Хог хаягдлын ачилт тээвэрлэлтийн бүртгэлийг айл өрхөөр дэлгэрэнгүй байдлаар хөтлөх, бүртгэлийн мэдээллийг нэгтгэх, айл өрхийн хог ачилтын эргэц хоногийг тооцоолох, хог ачилтын дуудлага өгөх, санал гомдол илэрхийлэх зэрэг ажлыг цахимжуулан, программ нэвтрүүлэх, хог хаягдлын хэмжээ, урсгалыг тогтмол хянаж байх;
2. Айл өрхийн хог ачилтын мэдээлэлд дүн шинжилгээ хийн, хүний нөөц, машин техник хэрэгслийн хуваарилалтыг оновчтой хийж ачааллыг тэнцвэржүүлэх, хог хаягдлыг тогтмол хугацаанд ачиж хог ачилтын эргэц хоногийг бууруулах;
3. Хог тээврийн автомашины жолооч, хог ачигч зэрэг хүнд хортой нөхцөлд ажиллаж байгаа ажилчдад холбогдох нэмэгдлийг олгох, нийт ажилтан албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж, ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах;

Сумдын Засаг дарга нар:

1. Сумдын төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулах, камержуулах, харуул хамгаалалттай болгох зэргээр байнгын хяналт тавих боломжийг бүрдүүлэн тохижуулж, зориулалтын бус газар хог хаяхгүй байх, зориулалтын бус газар төвлөрсөн хог хаягдлыг дарж, булшлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
2. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ, энгийн хог хаягдлыг цэвэрлэх цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг аргачлалын дагуу бодитой тогтоож, тус тарифт үндэслэн үйлчилгээ үзүүлэгч хувь хүн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан, биелэлтэд хяналт тавьж ажиллах;
3. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг цахилгааны төлбөртэй хамтатган авч төвлөрүүлэх арга хэмжээг судлан хэрэгжүүлэх, татвар төлөлтийн байдалд хяналт тавьж, тооцоо нийлж баталгаажуулах замаар орлогыг бүрэн төвлөрүүлж, хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөөний дагуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагаанд бүрэн зарцуулах;
Барилгын болон халаалтын зуухнаас гарах хог хаягдалд хяналт тавьж, батлагдсан хураамжийн дагуу гарсан хог хаягдлын хэмжээгээр төлбөрийн ногдуулалтыг хийж төсөвт хураамжийг бүрэн төвлөрүүлэх;